



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/699

Бсонбулаг

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/550 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг хэлэлцэх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.


- Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга  
Нарийн бичгийн дарга: Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга  
Нэгдсэн эмнэлгийн захирал  
Дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч  
Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч  
Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Шаардлагатай тохиолдолд аймгийн бусад төрөлжсөн мэргэшлийн эмч нар

2. Эхийн эндэгдлийн тохиолдол, ноцтой хүндрэл бүрийг нягтлан судалж, дунг хэлэлцүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг зөвлөлийн дарга (Г.Лхагважаргал)-д даалгасугай

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\Documents\ ZD A-4 doc